



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 дугаар сарын 22 өдөр Дугаар 28

Хэрлэн сум

ХХVIII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын цомхотгосон хурал 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 93.6 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөө.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1.Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргын баталсан удирдамжийн дагуу Чулуунхороот сум, Эрээнцав хилийн боомтод ажилласан тухай:

*Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,*

2.Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргын баталсан удирдамжийн дагуу Матад, Халхгол сумын Онцгой комиссын үйл ажиллагааг шалгасан тухай:

*Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой
комиссын орлогч дарга Ч.Ганбат,*

3.Аймгийн Баяндун, Баян-Уул суманд 2020 оны 04 дүгээр сарын 15-20-ны өдрүүдэд гарсан ой, хээрийн түймрийн талаарх мэдээлэл:

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар,

4.Улсын Онцгой комиссын 10 дугаар "Зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоох тухай" тогтоолын дагуу аймгийн Онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:

Аймгийн Цагдаагийн газар,

5.Улсын Онцгой комиссын 2020 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 504 дүгээр албан бичгийг танилцуулж хэлэлцүүлэх:

Бусийн төв аймгийн Онцгой байдлын газар

6.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар" 01/855 дугаар албан бичгийг танилцуулах.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Бат-Эрдэнэ,

7.Хачигаар дамжих халдварт өвчний талаар мэдээлэл танилцуулах:

Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн Халдвартын тасгийн дарга, их эмч Д.Оюунбилэ

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Гаалийн газрын дарга Б.Гэрэлт-Од,

Хилийн ангиудын захирагч нарт:

1.1.Монгол улсын Эрэнцав, Ульхан хилийн боомтуудын ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх тухай албан бичиг, хүсэлтийг дээд шатны байгууллагууддаа хүргүүлэх,

1.2.ОХУ, БНХАУ-ын хөрш зэргэлдээ аймгуудад Коронавируст халдварын өвчлөл гарсантай холбогдуулан хилийн болон гүний ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг эрчимжүүлэхийг,

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,

Онцгой комиссын гишүүн Б.Эрдэнэбаяр-т.

1.3.Галт тэргэнд ариутгал, халдваргүйтэл хийх пунктийн байгаль, орчны үнэлгээ хийлгэх асуудлыг шийдвэрлэхийг,

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн

хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д.

1.4.Чулуунхороот сумын гүүрийг барих асуудлыг эцэслэн шийдвэрлэхийг,

1.5.Өндөр хүчдлийн тулгуур баганын орчимд автозамын хөдөлгөөнийг үйлдүүлэхгүй байх, автозамын чиглэлийг өөрчлөх тухай албан бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж хяналт тавьж ажиллахыг,

Хоёр.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Ч.Оюунаа-д.

2.1.Матад сумын Эрүүл мэндийн төвд их эмч томилж ажиллах асуудлыг шийдвэрлэж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулахыг,

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн

хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа нарт.

2.3.Халхгол сумын хилийн Баянхошуу боомтын ажилчдын байрны өргөтгөлийн барилгын ажлыг хүлээж авсан тухай материалыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

2.4.Хилийн боомтод ажиллаж буй албан хаагч нарын онцгой нөхцөлд ажиллах хөдөлмөрийн нөхцөл, норм стандартыг аймгийн Онцгой комиссын 29 дүгээр хуралд танилцуулахыг,

2.5.Ой, хээрийн түймрийн хохирол тооцох журмыг аймгийн Онцгой комиссын 29 дүгээр хуралд танилцуулахыг,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор намрын улиралд, Баян-Уул, Баяндун, Дашбалбар сумын хилийн заагаар босоо болон хэвтээ тэнхлэгийн чиглэлд цурам татах ажлын зураглал, шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж танилцуулахыг,

3.2.Баян-Уул сум дахь Гал түймэр унтраах, аврах 53 дугаар ангид гэмшгийн үед холбоо зохион байгуулах зориулалттай хэт богино долгионы станцыг худалдан авах ажлын талаар тооцоог гаргаж танилцуулан хөрөнгийг аймгийн Засаг даргын нөвцийн сангаас шийдвэрлүүлэхийг,

3.3.Онон голыг гатлаж түймэр унтраах зорилгоор бирвазыг шинээр байрлуулах талаар судалгаа, тооцоог гаргаж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулахыг,

Сумдын Засаг дарга нарт:

3.4.Ой, хээрийн түймэр унтраах үлээгч аппаратыг сумдын төрийн байгууллагуудад хуваарилан өгч эзэнжүүлж ажиллахыг,

Дөрөв.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

4.1.Монгол Улсын Онцгой комиссын 2020 оны 10 дугаар тогтоолын дагуу хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 21:00 цагаас 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06:00 цаг хүртэл түр зогсоох арга хэмжээг авч ажиллахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.2.Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хэсэгчлэн түр зогсоох хугацаанд хяналт тавих 4 цэгт 2 хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэх 14 албан хаагч нарын хоолны зардал 280,000 төгрөг, шатахууны зардал 126,400 төгрөг, нийт 406,400 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг аймгийн Цагдаагийн газарт,

4.3.Доорх хүндэтгэх үзэх шалтгааны дагуу бичиг баримтыг үндэслэн зөвшөөрлийг олгоно.

4.3.1.Улаанбаатар хот руу АМ-13А маягт, Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрээр Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч даргын зөвшөөрлөөр,

4.3.2.Ар гэрийн гачигдал: Зөвхөн төрсөн талын гачигдлыг хүлээн авч нотлох баримтуудыг үндэслэн Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч даргын зөвшөөрлөөр,

4.4.Шатахуун түгээх аж ахуйн нэгж, байгууллагуудад хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 21:00 цагаас 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 08:00 цаг хүртэл түр зогсоосон тухай албан бичгийг хүргүүлэхийг,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбатад:

4.5.Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хэсэгчлэн түр зогсоох хугацаанд хяналт тавих цэгүүдэд хяналт, шалгалтыг зохион байгуулах хуваарийг боловсруулж батлуулахыг,

4.6.Гэмшгээс хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан орон нутгийн хэмжээнд хорио цээрийн дэглэмийг сахиулах, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Шүүх, Прокурорын газарт аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүнд оруулах албан тушаалтны нэрийг ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлэхийг,

Төв Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.1.Улсын Онцгой комиссын 2020 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 504 дүгээр албан бичгийн биелэлтийг мэргэжлийн байгууллагуудаас авч Улсын Онцгой комиссын Шуурхай штабт хүргүүлэхийг,

5.2.Халхгол сумын хилийн Баянхошуу боомтод ажиллаж буй Гадаадын харъяат, мэргэжлийн хяналт, гааль, цагдаа, хил хамгаалах байгууллагуудын албан хаагч нарт тус бүр N95 амны хаалт 50 ширхэг нийт 250 ширхэг амны хаалтыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас олгохыг,

Зургаа Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
"Дорнод нийтийн аж ахуй" ОНБААТҮГ-ын дарга, Онцгой комиссын гишүүн Г.Баярсайхан нарт:

6.1.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар" 01/855 дугаар албан бичгийг биелэлтийг гаргаж Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэхийг,

Долоо.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д

7.1.Иргэдийн дунд хорио цээрийн дэглэмийг сахиулах, бөөгнөрөл үүсгэхгүй байх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ганц бие өндөр настанд шаардлагатай эм, эмнэлгийн тусламж үйлчилгээг гэрээр хүргэх ажлыг зохион байгуулах, мэдээллийг иргэдэд хүргэхийг,

Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ө.Амарсайхан-д:

7.2.Коронавируст халдвар (COVID19)-аас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд, олон нийтийн бөөгнөрөл үүсгэхгүй байх тухай шийдвэрийн дагуу иргэдэд олгодог хөдөлмөрийн чадвараа алдсаны мөнгөн тэтгэмж, өндөр настны мөнгөн тэтгэмж олгох эрхийг тус тусад нь нээлгэх санлыг боловсруулж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад хүргүүлэхийг,

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэл-д:

7.3.Иргэдийн дунд хорио цээрийн дэглэмийг сахиулах, бөөгнөрөл үүсгэхгүй байх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ганц бие өндөр настанд шаардлагатай хүнс болон бусад тусламж үйлчилгээг гэрээр хүргэх ажлыг зохион байгуулах, мэдээ мэдээллийг иргэдэд хүргэхийг,

Найм.Аймгийн Онцгой комиссын нийт гишүүдэд:

8.1.Аймгийн Онцгой комиссоос гарсан шийдвэрүүдийн биелэлтийг Аймгийн Онцгой комиссоос 29 дүгээр хуралд танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАГИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.БАТТУЛГА